



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 12 дугаар сарын 25

Дугаар 9/148

Баян-Өндөр сум

**Ээлжит бус III хуралдаан
зарлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32¹.5 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Хурлын хуралдааны дэгийг шинэчлэн батлах тухай” 02/11 дүгээр тогтоолын 17.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн бүрэн эрхийн Ээлжит бус III хуралдааныг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 08.00 цагт танхим болон цахим хэлбэрээр зарлан хуралдуулж, дараах асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай.

1.1. Аймгийн 2025 оны төсөв батлах тухай;

1.2. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай;

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус III хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
даргын 2024 оны 12 дугаар сарын 25-ны
өдрийн 11/20 дугаар захирамжийн хавсралт



**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ БУС III ХУРАЛДААНЫ БЭЛТГЭЛ ХАНГАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус III хуралдааныг зарласан тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийг мэдээллээр хангах;

XII/25-ны дотор

Ажлын алба

2.Аймгийн 2025 оны төсөв батлах тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XII/25, XII/31-ний дотор

Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

3.Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XII/25, XII/31-ны дотор

Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

4.Техник зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангах;

XII/31-ний дотор

Нарийн бичгийн дарга Ш.Ганболд

АЖЛЫН АЛБА